

**“ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ” ТӨРИЙН ӨМЧИТ
ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2014 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр Дугаар 01 Улаанбаатар хот

“Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2014 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн 15.30 цагт Улаанбаатар хот, Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт байрлах “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн хурлын танхимд хийв.

Хуралд Хувьцаа эзэмшигчдийн итгэмжлэгдсэн төлөөлөгч С.Цэнд-Аюуш, Р.Мөнхтуяа болон Д.Дэлгэрцогт тусгай ажилтай байсан тул түүнийг төлөөлөн Эрчим хүчний яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Л.Батсайхан, компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооны дарга бөгөөд хараат бус гишүүн З.Мягмарсүрэн, гүйцэтгэх захирал Ж.Равдандорж, Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга З.Ганбаатар, Ерөнхий нягтлан бодогч Ц.Норовжамц нар оролцов.

Хурал 100 хувийн ирцтэй, хурлыг Л.Батсайхан удирдан хуралдуулав.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар:

1. “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн 2013 оны санхүүгийн тайлан тэнцлийн тухай
 - а/ Компанийн жилийн үйл ажиллагааны талаарх гүйцэтгэх удирдлагын тайлан
 - б/ Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах /ТУЗ-ийн болон Аудитын хорооны тайлан/
2. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2013 оны ажлыг дүгнэх, 2014 онд хийх ажлын төлөвлөгөөг батлах
3. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2013 оны зардлын гүйцэтгэл, 2014 оны зардлын төсвийг батлах
4. Ногдол ашгийн тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг танилцуулах
5. Компанийн өөрийн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлж компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах
6. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгож батлах
7. Иргэн Х.Гантөмөрийн орон сууцны тухай

зэрэг 7 асуудлыг хэлэлцүүлэхээр оруулав.

Хурлаар хэлэлцэх асуудлыг Л.Батсайхан танилцуулж гишүүдээс санал авахад иргэн Х.Гантөмөрийн орон сууцны тухай асуудлыг өмнө нь Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэсэн бөгөөд энэ асуудал нь хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал биш тул хэлэлцэх шаардлагагүй гэж гишүүд санал нэгтэй шийдвэрлэсэн тул хэлэлцэхгүй орхиж үлдсэн 6 асуудлыг хэлэлцэхээр батлав.

Нэгдүгээр асуудал: “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн 2013 оны санхүүгийн тайлан тэнцлийн тухай асуудлыг гүйцэтгэх захирал Ж.Равдандорж танилцуулав. /Холбогдох материалыг хавсаргав/

Л.Батсайхан: Равдандорж захирлын танилцуулсан асуудалтай холбоотой асуулт байна уу.

Р.Мөнхтуяа: Зохицуулалтын үйлчилгээний хөлс 100,0 сая төгрөгөөр нэмэгдсэн юмуу. Энэ яагаад ингэж нэмэгдсэн юм бэ.

Ж.Равдандорж: Өнгөрсөн жил манай зохицуулалтын үйлчилгээний хөлс 47,0 сая төгрөг байсан, харин энэ жил энэ зардал 100,0 сая болж нэмэгдсэн.

С.Цэнд-Аюуш: Эрчим хүчний зохицуулах хороо ингэж илүү авч болохгүй ш дээ.

Ц.Норовжамц: Манай компани өнгөрсөн жил Хятадаас цахилгаан импортлох, экспортлох тусгай зөвшөөрөл шинээр авсан юм. Тэгэхээр Эрчим хүчний зохицуулах хороо 2014, 2015, 2016 онуудын, 3 жилийнхээ үйлчилгээний хөлсийг бөөн авсан юм.

Л.Батсайхан: 2 тусгай зөвшөөрөл авсан юмуу.

Ж.Равдандорж: Тийм. Цахилгаан импортлох, экспортлох 2 тусгай зөвшөөрөл авсан юм.

Р.Мөнхтуяа: За яагаад аудитын хязгаарлалттай дүгнэлт авчихсан бэ. Нэг худалдан авагчаас болсон юм байна тиймүү.

Ц.Норовжамц: Тийм. Аудитын дүгнэлт яг тэгэж гарсан байгаа.

С.Цэнд-Аюуш: Аудитын дүгнэлтээр хязгаарлалттай дүгнэлт авна гэсэн чинь муу гэсэн үнэлгээ авч байна гэсэн үг шүүдээ.

Р.Мөнхтуяа: Аудитын дүгнэлтэд худалдан авалтын талаар хэд хэдэн зөрчил заасан байна. Энэ яагаад ингэсэн юм.

Ц.Норовжамц: Хэд хэдэн хийгдээгүй болон дутуу хийгдсэн ажлууд байгаа юм.

Ж.Равдандорж: “Боорч” ХХК-ийн асуудал шүүх дээр очоод эргэн тооцогдох гэрээгээр ажлаа гүйцээж хийхээр болоод одоо ажлаа эхлээд явж байгаа. Энэ компани 2,3 жилийн өмнө манай компанийн дэд станцуудын хашааг барихаар гэрээ нийгээд мөнгө аваад алга болсон, одоо энэ ажлаа л хийх гэж байгаа юм.

Р.Мөнхтуяа: Аудитын дүгнэлтэд дурдсан ажлууд бүгд ажлаа хийгээгүй, дутуу хийсэн, тэгээд мөнгө шилжчихсэн ажлууд юмуу.

Ж.Равдандорж: Тийм. Өөр нэг ажил нь сэйл реле тавих ажил мөн л одоо хийгдэж байгаа, нөгөө нэг ажил нь манай компанийн байрны урд талын үүдний тохижилтын ажил

юм. Зам өргөтгөх ажилтай холбоотой гарсан зардал. Энэ зардлыг бидэнд хотын гудамж төслөөс өгөхөөр шийдвэр гарчихсан байгаа.

Р.Мөнхтуяа: Өр авлага нэлээд хэмжээгээр өссөн байна, энэ яагаад өссөн юм бэ.

Ц.Норовжамц: Нэг худалдан авагчийн орлогыг дутуу төвлөрүүлсэнтэй холбоотойгоор манай компанийн дамжуулалт, импорт хоёрын авлага өглөг өссөн, харин өглөг өссөн шалтгаан нь итпорт өссөн, мөн хөгжлийн банкнаас 2,0 тэрбум төгрөгийн зээл авснаас өглөг өссөн.

Л.Батсайхан: Өөр асуулт байна уу. Алга. За тэгвэл ямар санал байна.

Санал:

С.Цэнд-Аюуш: Тогтоолын төсөл дээр Дэлгэрцогт даргад даалгасан заалтыг гүйцэтгэх захиралд даалгах болгон өөрчлөөд аудитын хязгаарлалттай дүгнэлтийн дагуу авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх талаар зааж өгч тогтоолын төслөө батлах саналтай байна.

Л.Батсайхан: Компаний 2013 оны үйл ажиллагааг хангалттай сайн ажилласан гэж дүгнэж байна. Тогтоолын төсөл дээр өөр санал алга. Аудитын хязгаарлалттай дүгнэлтийн дагуу авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, биелэлтийг дараагийн хувьцаа эзэмшигчдийн хурал дээр танилцуулах хэрэгтэй.

Р.Мөнхтуяа: Тогтоолын төсөл дээр байгаа компанийн 2013 оны эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшингийн үзүүлэлтийг үндсэнд нь ханган биелүүлсэн байна гэдэг заалтыг хасах саналтай байна. Яагаад гэхээр энэ тогтоолоор санхүүгийн тайлан тэнцлийн дүн баталж байгаа болохоор үүнийг хасаад тогтоолын төслийн 2 дугаар заалтыг 1 болгоод энэ заалтад компанийн нийт хөрөнгийг 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр гэж нэмэх саналтай байна.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. Тогтоолын төслийн Дэлгэрцогт даргад даалгасан заалтыг гүйцэтгэх захиралд даалгах болгон өөрчлөх
2. Аудитын хязгаарлалттай дүгнэлтийн дагуу авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, биелэлтийг дараагийн хуралд танилцуулах
3. Тогтоолын төслийн компанийн 2013 оны эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшингийн үзүүлэлтийг үндсэнд нь ханган биелүүлсэн байна гэсэн 1 дүгээр заалтыг хасах
4. Тогтоолын төслийн 2 дугаар заалтыг 1 дүгээр заалт болгоод энэ заалтад компанийн нийт хөрөнгийг 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр гэж нэмж найруулаад тогтоолын төслийг батлахаар гишүүд санал нэгтэй шийдвэрлэв.

Хоёрдугаар асуудал: Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн болон Аудитын хорооны 2013 оны ажлын тайлангийн тухай

а/ Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2013 оны ажлыг дүгнэх, 2014 онд хийх ажлын төлөвлөгөөг батлах тухай асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга Х.Очирхуяг танилцуулав. /Холбогдох материалыг хавсаргав/

Л.Батсайхан: Төлөөлөн удирдах зөвлөлийн 2013 оны ажлын тайлантай холбогдуулан гишүүдээс асуух асуулт байна уу. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас өгсөн үүрэг даалгаврын биелэлт хэдэн хувьтай байна.

Х.Очирхуяг: Өнгөрсөн оны хувьцаа эзэмшигчдийн хурлаас 3 багц үүрэг даалгавар өгсөн бөгөөд энэ үүрэг даалгавар бүрэн биелэгдсэн байна.

Л.Батсайхан: Энэ бөхөд орон сууц олгосон байсан. Энэ хүн танайд хэдэн жил ажиллаж байгаа юм.

Х.Очирхуяг: 3 жил гаруй хугацаанд ажиллаж байгаа. Өнгөрсөн жил улсын наадмаар начин болсон юм, тэгээд байр өгсөн.

Р.Мөнхтуяа: Нэг хүнд 20,0 сая төгрөг өгсөн байсан. Тэр хүн чинь хэр удаж байгаа хүн бэ.

Х.Очирхуяг: Энэ хүн бараг 20 гаруй жил, бараг насаараа л ажиллаж байгаа хүн, гэр бүлээрээ манай компанид ажилладаг юм.

Л.Батсайхан: За өөр асуулт байна уу. Алга. За тэгвэл аудитын хорооны тайланг нэг мөр сонсчихоод дараа нь саналаа хэлье.

б/ Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооны 2013 оны ажлын тайланг Аудитын хорооны дарга З.Мягмарсүрэн танилцуулав. /Холбогдох материалыг хавсаргав/

Л.Батсайхан: За асуулт байна уу.

С.Цэнд-Аюуш: Санхүүгийн олон улсын стандарт байхгүй юмуу, хуучирсан гээд яриад байна, энэ ямар учиртай юм бэ.

З.Мягмарсүрэн: Санхүүгийн олон улсын стандартад 2011-2013 онд өөрчлөлт орсон, тэр өөрчлөлтийн дагуу бодлогын баримт бичигтээ өөрчлөлт оруулаагүй байна гэж ярьсан юм. Мөн худалдан авах ажиллагаанд мөрддөг журмаа шинэчлээгүй, тэр журмаа мөрддөггүй зөрчил харагдаж байсан.

С.Цэнд-Аюуш: Яагаад өөрчлөлт оруулаагүй юм бэ.

Ц.Норовжамц: өөрчлөлт оруулж шинэчлээгүй 3, 4 жил болчихож байгаа, одоо өөрчлөлт оруулж шинэчлэнэ.

Л.Батсайхан: Барилга хүлээн авахад акт гарна, тэр актын маягт нь хуучирсан байгаа юмуу.

З.Мягмарсүрэн: Тийм, барилга хүлээж авсан акт, гэрээний маягт хуучирсан байналээ. Түүнийг л ярьж байна. Би энэ асуудлыг хөндлөнгийн аудит гэдэг утгаар л гаргаж байгаа юм.

С.Цэнд-Аюуш: Тийм, зөв ш дээ. Угаасаа хөндлөнгийн дүгнэлт л гаргах ёстой ш дээ.

Л.Батсайхан: Аудитын хороо дүгнэлт гаргаад үүнийгээ Төлөөлөн удирдах зөвлөлөөрөө хэлэлцүүлээд гүйцэтгэх захиралдаа үүрэг чиглэл өгөөд явах ёстой.

Ж.Равдандорж: Энэ аудитын дүгнэлтэд 2006 онд баталсан журмын дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулдаг гэж худлаа бичсэн байна. Би худалдан авах ажиллагааг бид тендерийн хууль гэж ярьдаг энэ хуулийн дагуу л зохион байгуулдаг. Би ийм журам байдаг гэдгийг анх удаа одоо л сонсож байна, огт хараагүй.

Л.Батсайхан: Равдандорж захирлаа бүгд л өнөөдөр тендерийн хуулиар ажлаа зохион байгуулж байгаа, гэхдээ 2006 онд энэ ажлыг зохион байгуулахаар гаргасан журмаа одоо хүртэл хүчингүй болгоогүй байгаа юм байна гэдгийг аудитын хүмүүс гаргаад ирсэн байна, энэ аудитын хүмүүс чинь бичиг баримт дээр л ажиллаж байгаа хүмүүс ш дээ, тэгэхээр та нар энэ журмаа хүчингүй болгох ёстой.

Санал:

Р.Мөнхтуяа: Төлөөлөн удирдах зөвлөлийн 2013 оны ажлыг дүгнэсэн тогтоол гарна, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2014 оны төлөвлөгөөг батлахгүй, энэ төлөвлөгөөгөө Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаараа батлах ёстой, мөн тогтоолын төслийн 2 дахь заалтыг аудитын байгууллагын болон аудитын хорооны зөвлөмжийг хэрэгжүүлэх, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах журмын тухай хуулийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулахад мөрдөх дүрэм, журам, маягтууд, гэрээний загварыг Сангийн сайдын тушаалаар баталсан байгаа тэр дүрэм, журам, маягт, гэрээний загварын дагуу шинэчлэн өөрчлөхыг гүйцэтгэх захиралд даалгахаар найруулах, 3 дахь заалтад Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын гишүүдийн идэвхи санаачлагыг дээшлүүлж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргад даалгах саналтай байна.

Л.Батсайхан: Тогтоолын төслийн 2 дахь заалтыг Мөнхтуяа гишүүний саналаар найруулах, аудитын болон аудитын хорооны зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган ажиллахыг үүрэг болгосон заалтыг нэмэх саналтай байна.

С.Цэнд-Аюуш: Төлөөлөн удирдах зөвлөлийн 2013 оны ажлыг хангалттай сайн гэж дүгнээд тогтоолын төсөлд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргад даалгах саналтай байна.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2013 оны ажлыг “хангалттай” гэж дүгнэсэн тогтоол гаргах
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2014 оны төлөвлөгөөг Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар батлах
3. Тогтоолын төслийн 2 дахь заалтыг аудитын байгууллагын болон аудитын хорооны зөвлөмжийг хэрэгжүүлэх, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулахад мөрдөх дүрэм, журам, маягтуудыг Сангийн сайдын тушаалаар баталсан дүрэм, журам, маягтуудын дагуу өөрчлөн шинэчлэхийг гүйцэтгэх захиралд даалгах гэж найруулах
4. Тогтоолын төслийн 3 дахь заалтад Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын гишүүдийн идэвхи санаачлагыг дээшлүүлж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргад даалгахаар тусгаж тогтоолын төслийг батлахаар шийдвэрлэв.

Гуравдугаар асуудал: Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2013 оны зардлын гүйцэтгэл, 2014 оны зардлын төсвийг батлах тухай асуудлыг Ерөнхий нягтлан бодогч Ц.Норовжамц танилцуулав. /Холбогдох материалыг хавсаргав/

Л.Батсайхан: За Төлөөлөн удирдах зөвлөлийн 2014 төсвийн асуудал дээр асуух асуулт байна уу.

Р.Мөнхтуяа: Төлөөлөн удирдах зөвлөлийн 2014 зардал компанийн зардлын төсөвтөө суусан уу.

Ц.Норовжамц: Суусан, 30,0 саяар суусан байгаа. Энэ нь өнгөрсөн жилийн төсөв.

Санал:

Р.Мөнхтуяа: Төлөөлөн удирдах зөвлөлийн 2014 зардлын төсөвт гишүүдийн цалин 250000 – 350000 төгрөгийн хооронд эрчим хүчний бүх компаниудыг адилхан нийтлэг жишгээр баталж байгаа, танай оруулж ирсэн цалингийн хэмжээ болох юм байна, харин жилийн үр дүнгийн шагнал, бичиг хэрэг, шатахууны зардалд төлөвлөсөн 4 564 000 төгрөгийг хасах, компани хөдөө орон нутагт олон салбартай учир томилолтын зардлыг хэвээр үлдээх, томилолтынхоо зардалд бичиг хэргийнхээ 384000 төгрөгийн зардлыг

багтаан батлах, энэ төсвийг 2014 оны 5 дугаар сарын 1-нээс эхлэн мөрдөх саналтай байна. Гишүүдийн жилийн үр дүнгийн шагнал компанийн ажилтнуудын шагналын санд багтаад явдаг, энэ журмаараа л явна.

С.Цэнд-Аюуш: Томилолтын зардлыг үлдээгээд жилийн үр дүнгийн шагнал, бичиг хэрэг, шатахууны зардлыг хасах, гишүүдийн цалинг оруулж ирсэн саналаар нь батлах, энэ төсвийг 2014 оны 5 дугаар сарын 1-нээс эхлэн мөрдөх саналтай байна.

Л.Батсайхан: Төлөөлөн удирдах зөвлөлийн 2014 зардлын төсвийн талаар Мөнхтуяа, Цэнд-Аюуш нарын гишүүдтэй санал нэг байна.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2014 зардлын төсөвт Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын цалинг 350000 төгрөгөөр, гишүүдийн цалинг 300000 төгрөгөөр, нарийн бичгийн даргын цалинг 250000 төгрөгөөр батлах
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2014 оны төсвөөс жилийн үр дүнгийн шагнал, бичиг хэрэг, шатахууны зардалд төлөвлөсөн 4 564 000 төгрөгийг хасах
3. Томилолтын зардлыг хэвээр үлдээж томилолтынхоо зардалд бичиг хэргийнхээ 384000 төгрөгийн зардлыг багтаан тусгах
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2014 зардлын төсвийг нийт 46 443 617 төгрөгөөр батлах
5. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2014 зардлын батлагдсан төсвийг 2014 оны 5 дугаар сарын 1-нээс эхлэн мөрдүүлэхээр шийдвэрлэв.

Дөрөвдүгээр асуудал: Ногдол ашгийн тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг Ерөнхий нягтлан бодогч Ц.Норовжамц танилцуулав. /Холбогдох материалыг хавсаргав/

Л.Батсайхан: Ногдол ашгийн асуудлаар гаргасан Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийн талаар гишүүдэд асуух асуулт байна уу. Алга. Санал байна уу. Алга.

Л.Батсайхан: За тэгвэл хуралд оруулж ирсэн тогтоолын төслийг батлах уу. Гишүүд санал нэгтэй батлахаар дэмжив.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ: “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” төрийн өмчит хувьцаат компани 2013 оны аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан тэнцлээр 3067.7 /гурван тэрбум жаран долоон сая долоон зуун мянга/ төгрөгийн алдагдалтай ажилласан тул ногдол ашиг хуваарилахгүй байх нь зүйтэй гэж үзээд энэ асуудлаар тогтоол гаргахаар шийдвэрлэв.

Тавдугаар асуудал: Компанийн өөрийн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлж компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай асуудлыг Ерөнхий нягтлан бодогч Ц.Норовжамц танилцуулав. /Холбогдох материалыг хавсаргав/

Л.Батсайхан: За гишүүдээс асууж тодруулах зүйл байна уу.

Асуулт:

Р.Мөнхтуяа: Энэ жагсаалтад байгаа хоёр гурван машинуудыг дүрмийн сангаа нэмэгдүүлэхээр оруулаад байгаа юмуу.

Ц.Норовжамц: Эдгээр машинуудыг балансаас балансад авсан юм, тэгээд оруулсан.

Р.Мөнхтуяа: Зөвхөн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар авсан хөрөнгөөр дүрмийн санг нэмэгдүүлэх ёстой. Балансаас балансад шилжиж ирж байгаа хөрөнгийг аудит орлого гэж бүртгэнэ гэхгүй байна уу. Үнэ төлбөргүй орж ирж байгаа хөрөнгө гэдгээрээ орлого гэж орж ирнэ ш дээ.

С.Цэнд-Аюуш: Энэ жагсаалтад байгаа өнгөт принтер, гүйлтийн зам зэргээр дүрмийн сан нэмэгдүүлээд байхдаа яахав, эдгээрийг хасах хэрэгтэй. Туул дэд станц чинь орсон юмуу.

Ц.Норовжамц: Орсон орсон, ард байгаа.

Санал:

Л.Батсайхан: За өөр асуулт байна уу. Алга. За тэгвэл саналаа хэлье.

Р.Мөнхтуяа: Оруулж ирсэн дүнгээ жаахан засаарай. 34,0 сая хасагдана шүү. Өөр санал байхгүй.

С.Цэнд-Аюуш: Санал байхгүй.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ: Хуралд оруулж ирсэн тогтоолын төслийн хөрөнгийн дүнг 34,0 саяар хасаж засаад батлахаар гишүүд санал нэгтэй шийдвэрлэв.

Зургаадугаар асуудал: Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгож батлах тухай асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга Х.Очирхуяг танилцуулав. /Холбогдох материалыг хавсаргав/

Л.Батсайхан: Энэ асуудал дээр гишүүдэд асуух асуулт байна уу.

С.Цэнд-Аюуш: Төлөөлөн удирдах зөвлөлийн хоёр гишүүнийг солих санал оруулж байгаа юмуу.

Л.Батсайхан: Тиймүү, тэр хоёр гишүүний нэр нь орж ирсэн юмуу.

Х.Очирхуяг: Эрчим хүчний яамны төлөөлөл Д.Чимэддорж, Бямбасүрэн нар өөр ажилд шилжсэн учир Чимэддоржийн оронд тус яамны хэлтсийн дарга Л.Ганхуягийг томилохоор

92

Төрийн өмчийн хорооны тогтоол ирсэн байгаа, харин Бямбасүрэнгийн оронд томилох хүнээ Төрийн өмчийн хороонд явуулсан боловч хорооны хурал хийхгүй байгаа болохоор хариу ирээгүй хүлээгдэж байгаа. Бусад гишүүд ажлаа хэвийн гүйцэтгэж байгаа учир тэдгээрийг улируулан томилуулахаар оруулж ирсэн.

Л.Батсайхан: Хараат бус гишүүд дээр асуудал байхгүй юу. Хараат бус гишүүдээр хэн хэн ажиллаж байгаа вэ.

Х.Очирхуяг: Арслаа, Доржпүрэв, Мягмарсүрэн нар ажиллаж байгаа.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ: Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр Ү.Арслаа, Ж.Доржпүрэв, З.Мягмарсүрэн нарыг улируулан томилох, бусад гишүүдийг Төрийн өмчийн хорооны тогтоол ирсний дараа томилохоор гишүүд санал нэгтэй шийдвэрлэв.

Долоодугаар асуудал: Иргэн Х.Гантөмөрийн орон сууцны тухай асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга Х.Очирхуяг танилцуулав. /Холбогдох материалыг хавсаргав/


Хэлэлцсэн нь:

Иргэн Х.Гантөмөрийн орон сууцны тухай асуудлыг өмнө нь Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцээд Гантөмөрийн өмчлөлд шилжүүлэхийг дэмжсэн шийдвэр гаргасан болон энэ асуудлыг Төрийн өмчийн хорооноос Засгийн газарт оруулан шийдвэрлүүлэх журамтай учир хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх боломжгүй гэж гишүүд санал нэгтэй тогтов.


ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Иргэн Х.Гантөмөрийн орон сууцны тухай асуудал нь хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал биш байх тул хэлэлцэхээс түдгэлзэх нь зүйтэй гэж гишүүд санал нэгтэй шийдвэрлэв.

ХУРАЛ УДИРДСАН:

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН
ТӨЛӨӨЛӨГЧ  Д.ДЭЛГЭРЦОГТ

Тэмдэглэл хөтөлсөн:

Төлөөлөн удирдах зөвлөлийн
нарийн бичгийн дарга  Х.Очирхуяг